

## **БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 03 ДУГААР САРЫН МЭДЭЭ**

### **Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар:**

#### ***Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:***

Булган аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурал боллоо.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хуралд тус зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Алтаншагай 2018 оны ажлын тайланг танилцуулж, 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталлаа. Энэ жил тус зөвлөлөөс ой, ан, уул уурхайн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилт болон шашин сүм хийдийн чиглэлээр зургаан удаагийн шалгалт хийж, архидан согтуурах, хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэл, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулахаар төлөвлөөд байна.

#### ***Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:***

Монгол улсын Засгийн газрын “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 2017 оны 01 тоот албан даалгавар, 258 дугаар тогтоолын хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтыг 2019 оны 03 дугаар сарын 05-10-ны өдөрүүдэд хийж, аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний 21 байгууллага хамрагдлаа. Шалгалтын дүнг аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцээд тогтоолын хэрэгжилтэд үр дүн гарч байгаа боловч сахилга хариуцлага, дэг журмыг үйл ажиллагаандаа хэвшил болгон ажиллах нь зүйтэй гэж дүгнэн 17 ажил бүхий үүрэг даалгаврыг агентлаг, байгууллагуудад хүргүүлээ.

Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академитай хамтран “Төрийн албаны тухай хууль, тогтоомж”, “Төрийн байгууллагын стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй”, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах арга зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж сум, байгууллагын удирдах албан тушаалтан, хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтнүүд зэрэг 400 гаруй албан хаагчид хамрагдлаа.

Булган аймгийн 16 суманд зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа. 16 сумын 80 төр, төсвийн байгууллагад Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил, архив албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг болон хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт, нийгмийн бодлогын чиглэлээр бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлж буй байдалтай танилцаж, зөвлөгөө өгч ажиллалаа.

#### ***Гадаад харилцааны чиглэлээр:***

2019 оны 03 дугаар сарын 12-14-ны өдрүүдэд Булган аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг ОХУ-ын Буриад улсад ажлын айлчлал хийж, хөдөө аж ахуй, боловсрол, соёлын салбарын хамтын ажиллагааг улам бүр эрчимжүүлэхээр харилцан санал солилцсон.

2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 4 дүгээр сарын 02-ны өдрүүдэд Булган аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг ОХУ-ын Красноярск мужид айлчилж, “Бүс нутгийн өрсөлдөх чадвар” сэдвээр зохион байгуулагдсан Эдийн засгийн форумд оролцлоо. Мөн өдөр Красноярскийн хязгаарын Хөдөө, Аж Ахуйн Их Сургуульд зочилж,

дугуй ширээний хэлэлцүүлэгт оролцсон бөгөөд хэлэлцүүлгээр тус сургуульд Булган аймгаас оюутан сургах, хамтарсан үйлдвэр байгуулах боломж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулахад технологийн дэмжлэг үзүүлэх, бизнес эрхлэгчдийг сургалтад хамруулах, мэргэжилтэн солилцох талаар санал солилцон тохиролцсон болно. Красноярск мужтай хөдөө аж ахуй, аялал жуулчлалын салбарт хамтран ажиллахаар тохиролцсон байна.

2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Япон улсын “Күбота Монгол” ХХК-ын төлөөллийг хүлээн авч, албан уулзалт хийсэн. Күбота корпораци нь хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, засвар үйлчилгээ эрхэлдэг бөгөөд энэ удаагийн уулзалтаар “Күбота Монгол” ХХК болон Булган аймгийн хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:**

2019 оны 3 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр нийт орлого ба тусламжийн дүн **14.1** тэрбум төгрөг буюу **97.6** хувийн, нийт зарлага **12.5** тэрбум төгрөг буюу **77.2** хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт орлого ба тусламжийн дүн 4,5 хувь, урсгал орлого 15,4 хувь, нийт зарлага 6,3 хувиар тус тус өссөн дүнтэй байна. Нийт орлогоос аймгийн төсвийн орлого **6.3** тэрбум төгрөг буюу **102.8** хувийн, сумдын төсвийн орлого **7.9** тэрбум төгрөг буюу **93.8** хувийн гүйцэтгэлтэй байна. Урсгал орлогын гүйцэтгэл 6.0 тэрбум төгрөг буюу 95,1 хувь байна.

Улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгээр **394.4** сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээр **7,275.8** сая төгрөг, санхүүгийн дэмжлэгээр **403,2** сая төгрөг олгосон байна.

Аймгийн дүнгээр авч үзвэл хадгаламжийн хүүгийн орлого, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, авто тээвэр өөрөө явагч хэрэгслийн албан татвар, газрын төлбөр, ус рашааны нөөц ашигласны төлбөр, төсөвт байгууллагын өөрийн орлого биелж, бусад орлого тасарсан байна. Бугат, Дашинчилэн, Сайхан, Сэлэнгэ, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Хялганат сумын урсгал орлогын төлөвлөгөө биелж бусад сумын урсгал орлогын төлөвлөгөөний биелэлт 40,1%-95,1% байна.

Аймгийн төсвийн нийт зарлага **12493,2** сая төгрөг буюу **77,2** хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс орон нутгийн төсвийн байгууллагуудын зардал **3771.9** сая төгрөг буюу **60.4** хувь, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зардал **8721,3** сая төгрөг буюу **87.8** хувь байна. Сумдад **1590.7** сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад **7275.8** сая төгрөгийн шилжүүлгийг тус тус олголоо. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр аймгийн төвийн УДДТ-1,2,3-аас 1-р сургууль, үйлдвэрийн зуух, 2-р сургууль хүртэлх гадна дулааны шугамын өргөтгөлийн зураг төсвийн эхний шатны санхүүжилт 25.0 сая, Сайхан сумын 320 хүүхдийн суудалтай сургууль, 100 хүүхдийн дотуур байрны зураг төслийн ажлын санхүүжилт 52,7 сая, Булган сумын 6Д хэсгийн гэр хорооллын ариутгах татуургын шугамын зураг төслийн ажлын санхүүжилт 8,0 сая, Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр байгаль орчны хохирлын үнэлгээнд 19,2 сая төгрөгийн гүйцэтгэл тус тус гарсан байна.

Нийт өр 89,8 сая, авлага 0,2 сая төгрөг байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал өр 181,4 сая, авлага 0,3 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна.

Аймгийн төрийн сангаар үйлчлүүлэгч төсвийн байгууллагын 4457 ширхэг гүйлгээгээр 13,0 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

### **Гурав: Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

2019 оны эхний 1 дүгээр улиралын байдлаар хуулийн байгууллагуудын хамтарсан зөвлөгөөнийг 2 удаа, төрийн тусгай алба хаагчдад соён гэгээрүүлэх,

нөлөөллийн сургалтыг 6 удаа зохион байгуулж шинээр хэрэгжиж эхэлсэн Төрийн албаны тухай хууль болон түүнийг дагаж мөрдөх журмууд, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр зөвлөмжийг өгч хамтран ажиллалаа.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан Хил хамгаалалтад туслах хүчний орон тооны бус зөвлөлийн зөвлөгөөнийг зохион байгуулж 2018 оны ажлын тайланг хэлэлцэж, 2019 оны төлөвлөгөөг баталж, ажил эрчимжүүлэх чиглэлээр аймгийн Засаг даргын албан даалгаврыг батлан, бүх шатны төрийн байгууллагуудад хүргүүлсэн.

Нутгийн захиргааны байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлын хүрээнд 2019 оны аймгийн Засаг даргын 205, 6 сумын Засаг дарга, Тамгын газрын даргын 320 шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянаж зөвлөмж чиглэлийг өгөөд байна.

2019 онд зохион байгуулагдах архив, албан хэрэг хөтлөлтийг улсын үзлэгт бэлтгэл хангах ажлын хүрээнд Архивын ерөнхий газартай хамтран албан хэрэг хөтлөлтийг сургалтыг зохион байгуулж, арга зүйн зөвлөмжөөр хангалаа.

Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу сумдад зөвлөн туслах ажлыг зохион байгууллаа.

### ***Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:***

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар аймгийн хэмжээнд 122 гэмт хэрэг бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 53 хэргээр буюу 76,8 хувиар өссөн байна. Нийт БҮСТЗЭТХэрэг 105 бүртгэгдэж 26 хэргийг илрүүлэн, гэмт хэргийн илрүүлэлт 24,8 хувьтай байгаа нь оны мөн үеэс 5,2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улаанбаатар-Дарханы чиглэлийн авто замыг 2019 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хаах болсонтой холбогдуулан хойд чиглэлийн Хөвсгөл, Орхон, Булганы тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг Булган-Баяннуур-Дашинчилэн чиглэлээр аймгийн төвөөр дайрч өнгөрөх маршрут батлагдсантай холбогдуулан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээрх ажлуудыг хийж эхлээд байна.

Дээрх ажлын хүрээнд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 15 сая төгрөгөөр замын эргүүл, урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулахад жижиг оврын автомашин, аймгийн ГХУСАЗЗ-өөс 15 сая төгрөгийн хурд хэмжигч авч өгөхөөр шийдвэрлээд байна. Мөн холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах замын тэмдэг тэмдэглэгээг хийж эхэллээ.

### ***Эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр:***

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг боловсруулж, аймгийн ИТХ-аар батлуулан хэрэгжүүлж байна.

2019 оны 1 дүгээр улирлын байдлаар албан бус сургалтыг 12 удаа зохион байгуулж 1200 гаруй иргэнийг хамрууллаа. Мөн сумдад зайны сургалтыг 4 чиглэлээр зохион байгуулж 68 албан хаагчийг хамруулсан.

Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан эрх зүйн багийн ажлыг эрчимжүүлэн 22 эрх зүйн хөтөч бэлтгэгдэж 3 удаагийн давтан сургалтыг хийн, ном, гарын авлага, зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Тус ажлын хүрээнд төвөөс алслагдсан 16 багийн иргэдэд эрх зүйн мэдлэг олгох сургалтыг хийж 200 гаруй иргэнийг хамруулсан байна.

### ***Дөрөв: Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:***

Аймгийн Засаг дарга З.Батзориг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 20 сургуулийн захирал, 22 цэцэрлэгийн эрхлэгч нартай энэ онд ажиллах хөдөлмөрийн гэрээг байгууллаа.

Боловсролын салбарын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөн 2019.04.04-06-ны өдрүүдэд амжилттай болж өндөрлөлөө. Сургалтаар СӨБ, ЕБС-ийн удирдлагууд, нягтлан бодогч нарын манлайллыг нэмэгдүүлэх, цаг үеийн шинэлэг мэдээ, мэдээллээр

хангах, санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх, цаашид баримтлах үйл ажиллагааны чиглэл өгөх зорилгоор дараах байгууллагуудтай хамтран сургалт, мэдээлэл хийлээ. Үүнд: БСШУСЯ-СХОГ, Сангийн яам, МУБИС-БУУТ, НБХ, Аймгийн Аудит, Архив, Газрын харилцаа хот байгуулалтын газар, Мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн даатгал, Татварын хэлтэс, Орон Нутгийн Өмчийн Газар, СТС компани, ЭМГ, ХХААГ, Булган Аймаг ГБХЗХГ, Цагдаагийн газар, Онцгой байдлын хэлтэс, БСУГ-ын холбогдох мэргэжилтнүүд тус бүр мэдээ мэдээлэл хийж, сургалт зохион байгууллаа. Мөн МУБИС, ДУТС-иас гаргасан Бүрэн дунд боловсролын сургуулиудад нэн шаардлагатай дизайн технологийн 10-12 дугаар ангийн "Механик электроник" агуулгын хүрээнд хэрэглэгдэх сургалтын багц хэрэглэгдэхүүнийг сургуулиудад хүргэлээ.

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн тогооч нарт "2-12 НАСНЫ ХҮҮХДИЙН ХООЛНЫ ОНЦЛОГ" сэдвээр Монголын хүний нөөцийн хөгжлийн ассоциацийн захирал, проф С.Наранбаатар, МУ-н Зөвлөх инженер, МУ-н мастер тогооч Л.Баярмаа, Монголын хүний нөөцийн хөгжлийн ассоциацийн сургагч багш дэд проф Д.Оюунцэцэг, МУ-н мастер тогооч Г.Долгормаа нар сургалт амжилттай зохион байгууллаа. Уг сургалтаар онолын болон дадлагын ажил зохион байгуулагдаж тогооч нар "СЕРТИФИКАТ" гардан авлаа.

Биологи, Англи хэл, Газарзүй, Технологи, Математик, Монгол хэл бичиг, Нийгэм, Түүхийн хичээлүүдээр Улсын төрөлжсөн 54-р олимпиадын хоёрын даваанд 900 гаруй багш суралцагчид оролцон шилдгүүдээ шалгарууллаа.

**Нийгмийн халамжийн чиглэлээр:** Нийгмийн халамжийн багц хууль, бодлогын баримт бичиг, Засгийн газрын тогтоол, шийдвэр, бусад эрх зүйн акт, баримт бичгийн биелэлтийг ханган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан нийгмийн халамжийн сангийн зарцуулалтын гүйцэтгэлд хяналт тавих, иргэдэд олгох тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг цаг хугацаанд нь чирэгдэлгүй олгож, нийгмийн халамжийн зорилтот бүлэгт чиглэсэн үйл ажиллагаа явуулахад онцгой анхаарч иргэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.

2019 оны 1-3 дугаар сарын байдлаар нийгмийн халамжийн сангийн зардлыг зарцуулалтаар авч үзвэл:

- Халамжийн тэтгэвэр 981 иргэнд 469091360 төг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 1284 иргэнд 270352140 төг
- Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай иргэдэд үзүүлэх хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид 1161 иргэнд 141186530 төг
- Ахмад настан 268 иргэнд 60130500 төг
- Хөгжлийн бэрхшээлтэй 63 иргэнд 13812950 төг
- ЖХЭТэтгэмж 584 иргэнд 48903070 төг
- Цалинтай ээж хөтөлбөрт 2858 эхэд 360768200 төгрөг
- Ихэр хүүхдийн тэтгэмж 6 иргэнд 12000000 төгрөг
- Өрх толгойлсон эх/эцэгт олгох тэтгэмж 68 иргэнд 21013340 төгрөг
- АЦАТэтгэмж 28 ахмадад 13238710 төгрөг
- Насны хишиг 2945 ахмадад 241020000 төгрөг
- Алдарт эхийн одон 5349 ээжид 700700000 төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа шаардлагатай 11924 иргэнд 112868000 төгрөг тус тус зарцуулсан байна.

Сумдын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнүүдэд Нийгмийн халамжийн хуулийн хэрэгжилт, өөрчлөлт, сар улирлын тайлан мэдээний чанар, анхаарах асуудлууд, тулгамдаж байгаа хүндрэл бэрхшээл, зорилтот өрхүүдтэй хэрхэн ажиллах талаар чиглэл хүргүүлэн ажилласан. ХХҮГазартай

гэрээ байгуулсан протез, ортопедийн хэрэгсэл нийлүүлэх байгууллагуудтай хамтран ажиллаж хуулийн заалт хангасан иргэдэд үйлчилгээг үзүүлэн санхүүжилтыг олгосон.

Нийгмийн халамжийн багц хуулинд өөрчлөлт орсонтой холбогдуулан “Хууль сурталчлах” ажлыг 2/07-02/15 хугацаанд мэргэжилтэнүүд төрийн болон хувийн хэвшлийн 22 ААН, байгууллагын 575 иргэнд хөдөлмөрийн тухай хууль, нийгмийн халамжийн багц хуулийн талаар мэдээ мэдээлэл хүргэж, гарын авлага, зөвлөгөө өгч ажилласан.

Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль 2017.06.30 батлагдаж 2018.01.01-ээс хэрэгжиж байна. Батлагдсан хуулийн дагуу орон нутагт иргэдэд мэдээлэл хүргэж тэтгэмжийг олгож эхлээд байна. Аймгийн хэмжээнд “Цалинтай ээж хөтөлбөрт” 1323 иргэн хамрагдаж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/205 тоот тушаалаар хүнсний эрхийн бичгийн босго оноог /292.5/-аар тогтоож, хүнсний эрхийн бичгийг сард олгох мөнгөн дүнг хүүхдэд- 8000 төгрөг, насанд хүрсэн хүнд-16000 төгрөг болгон нэмэгдүүлж, иргэдэд үйлчилгээг цаг хугацаанд нь чирэгдэлгүй хүргэж, хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх дэлгүүр болон үйлчилгээ авах иргэдтэй уулзалт зохион байгуулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/13 тоот тушаалаар нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх-иргэнд хүнсний эрхийн бичиг олгох босго оноог аймагт 310.0 ба түүнээс доош тогтоож, хүнсний эрхийн бичиг олгох журамд хэд хэдэн заалтыг нэмж шинэчлэн баталсаныг хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 1018 Өрх хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд хамрагдаагүй аймгийн хэмжээнд 1202 хүүхэд байгаа бөгөөд тус хүүхдүүд хүүхдийн мөнгөнд хамрагдах боломжгүй тул судалгаанд хамрагдах тухай мэдэгдлийг хүргүүлж ажиллалаа. Булган аймгийн хэмжээнд 11979 өрхийн 46930 иргэн судалгаанд хамрагдсан.

**Зорилтот бүлэгүүд рүү чиглэсэн үйл ажиллагаа:** “Эрсдэлээс хамтдаа сэргийлье” аян өрнүүлж 9 ажил төлөвлөж, тус бүрт төлөвлөгөө боловсруулан Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Улаан загалмай нийгэмлэгтэй хамтран хүнд нөхцөлд амьдарч байгаа 10 өрхийн хүүхэд, эмэгтэйчүүдэд дулаан хувцас хүнсний бүтээгдэхүүн хандивлаж, урьдчилан сэргийлэх эмчийн үзлэгт хамруулан өрх толгойлсон 2 эмэгтэйн нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажлын байраар хангасан.

Мөн 1,2 дугаар 12 жилийн сургууль, Биеийн тамир, спортын сургуулийн 8-9 дүгээр ангийн 158 охид, 68 хөвгүүдийг өсвөр үеийн эмчийн үзлэг хамруулан 226 охид, хөвгүүдэд нөхөн үржихүйн чиглэлээр мэргэжлийн эмч зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.11-12 дугаар ангийн 400 сурагчдад охид, хөвгүүдийн бэлгийн амьдралын эрүүл ахуй, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сэдвээр эрүүл мэндийн газартай хамтран сургалт зохион байгуулсан.

Аймгийн Стандартчлал хэмжил зүйн газар, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Иргэний зөвлөлтэй хамтран Булган суманд үйл ажиллагаа явуулж байгаа 3 цахим тоглоомын газруудад хяналт шалгалт явуулсан.

2019 онд Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 409,0 хүртэлх оноотой өрхүүдээс өөрсдөө хөгжих хүсэл эрмэлзэлтэй, идэвхтэй, хөдөлмөрийн насны иргэнтэй өрх сонгон, өрхийн байршил, сонирхол зэрэг үзүүлэлтээр бүлгийн зохион байгуулалтад оруулах,

нэгдэж хөгжихөд нь дэмжлэг үзүүлж ажиллахаар сумдын засаг дарга нар болон Хөдөлмөр халамжийн үйлчилгээний мэргэжилтэнгүүддээ чиглэл хүргүүлсэн. Мөн 409,0 онооноос доош оноотой өрхөөс амьжиргааг нь дээшлүүлэхээр сонгосон өрхийн дэлгэрэнгүй судалгааны маягтыг хүргүүлж мэдээллийг авч эхлээд байна.

**Хөдөлмөр эрхлэлтийн чилэлээр:** Булган сумаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2015 онд хэрэгжүүлсэн “Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд, 2014, 2015, 2016 онд “Малчдын хөдөмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт тус тус хамрагдсан иргэдийн судалгааг гаргаж жтл бүр судлгааг баяжуулж байна.

Сумдаас Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой суурь судалгааг 5 чиглэлээр гаргуулан авч байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн “Жижиг зээл”-д хамрагдахаар хүсэлт ирүүлсэн 4 аж ахуйн нэгж, иргэний материалыг Голомт банкинд хүргүүлсэн. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн “Жижиг зээл”-д 19 Аж ахуйн нэгж, иргэнд 270 сая төгрөгний зээлийг олгон 2 аж ахуйн нэгж, иргэний материалыг судалж байна.

2019 он хэрэгжих Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрүүд батлагдан ирж батлагдсан төсөл хөтөлбөрүүдтэй танилцаж судалж, төсөл авах хугацааг тодорхой болгож зарыг иргэдэд хүргэж төслөө хүлээн авч байна.

Ажилд зуучлал: Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг хүргэх иргэдийн орлогыг нэмэгдүүлэх болон иргэдийг ажлын байраар хангах, ажилд зуучлах үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Ажил хайгч 71 иргэнийг хөдөлмөрийн эрхлэлтийн бүртгэл мэдээлэлийн LMIS програмд идэвхижүүлсэн

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн харилцаа, ХАБЭА-н асуудал: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн аймгийн зөвлөл байгуулах тогтоолын төсөл, аймгийн дэд хөтөлбөрийн төсөл, зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө, Байгууллагад ХАБЭА-н ажил болон бүтээмжийн хөдөлгөөн өрнүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл зэргийг гарган ХЭХ-н даргад танилцуулан ажиллаа. Шилэн дансанд ХАСХОМ-той холбоотой мэдээ мэдээллийн хуулийн дагуу хугацаанд холбогдох газар нь хүргүүлээ. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээг 15 иргэнд, ЭӨЦС-ийн 12-р ангийн 83 сурагчдад “Мэргэжлээ сонгох нь” сэдэвт сургалт явуулав.

Нийгмийн халамжийн багц хууль болон Хөдөлмөрийн асуудлаар мэдээлэл өгч нийт 98 ажилтан, иргэнийг хамруулсан байна.

**Гэр бүлийн хөгжил хамгааллын чиглэлээр:** Сум, сургуулийн нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах “Гэр бүлд Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй” 2 дахь шатны сургалтыг “Монгол Өрх” сэтгэл зүйн хүрээлэнгийн захирал С.Баасанбат багшаар удирдуулан зохион байгууллаа. Сургалтад нийт сум, сургуулийн 43 нийгмийн ажилтнууд хамрагдаж гэр бүл, архины хамаарал, бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, гэр бүлтэй ажиллах бүрэн арга зүйг эзэмшиж авсан.

Олон Улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан ЕБ-н 3-р сургуультай хамтран сэтгэл зүйч Л.Мөнхчимэг “Охидын Шивнээ” бүлгийн уулзалт ярилцлагыг зохион байгуулж өсвөр насны охидод бэлгийн хүчирхийлэл, болон

дарамтад орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах арга зүйг зааж, ярилцлага хийж ажиллаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажил үйлчилгээг чанаржуулах зорилгоор хамтарсан багийн гишүүдийн үүрэг хариуцлагыг сайжруулах, чадавхжуулах сургалтыг Цагдаа, БСУГ, Прокурор, аймгийн Шүүх, Залуучуудын хөгжлийн төв, ГХУССЗөвлөл зэрэг байгууллагуудтай хамтран 17 сумын 23 хамтарсан баг, 130 гишүүдийг хамруулан зохион байгууллаа. Сургалтаар гишүүдэд хамгааллын үйлчилгээний өнөөгийн байдлын талаар мэдээлэл өгөхөөр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын Хууль эрх зүйн газрын дарга н.Энхбаатар сургалт хийлээ. Мөн сургалтаар салбар тус бүрт сургалт хэлэлцүүлэгийг зохион байгуулж, тулгамдсан асуудал болон ололттой талууд, цаашид хэрэгжүүлж болохуйц ажил үйлчилгээг ярилцан санал сэтгэгдлээ хуваалцаж зөвлөгөөн амжилттай зохион байгуулагдлаа.

Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх танхим Гэр бүлийн радио 104.5-тай хамтран сэтгэл зүйн зөвлөгөө өгөх нэвтрүүлгийг сар бүр тогтмол хийж байна. Энэ сарын зөвлөгөө өгөх нэвтрүүлгээр хүүхэд хамгаалал гэж юу вэ?, түүнд хариу үйлчилгээг хэрхэн үзүүлэх вэ? сэдвээр чөлөөтэй ярилцлаа.

Хялганат тосгонд Аз жаргалтай гэр бүл хөгжлийн үйлчилгээний хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран тосгоны иргэдэд зориулсан зөвлөгөөнд гэр бүлийн хөгжил хамгааллын албанаас Гэр бүлийн боловсрол-Эрүүл мэнд сэдвээр 200 иргэдэд сургалт зохион байгууллаа.

ШШГГазартай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд Зөвлөгөө өгөх танхимаар зан үйлийн сургалтыг явуулж хэвшсэн. 3-р сард Зан үйлээ засах сургалтанд 6 хүн хамрагдсан. Мөн ШШГГ-ын 20 алба хаагчид “Гэр бүлийн харилцаа, тулгамддаг асуудал” сэдвээр сургалт зохион байгууллаа.

### ***Хүүхэд, залуучуудын хөгжил хамгааллын чиглэлээр:***

Хүүхэд залуучуудын хөгжлийн ордны дэргэд ёочин, морин хуур, дуу, хар зургийн дугуйлан хичээллэж эхлээд үйл ажиллагаа нь тогтворжиж байна.

Хүүхдийн парламентын тэргүүлэгчид Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалах өдрийг тохиолдуулан захидлын уралдааныг 2 дугаар сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 6-ны өдрүүдэд дунд зохион байгууллаа.

ГБХЗХГ-ын үйл ажиллагаа, Залуучуудын хөгжлийн тухай хуулийн танилцуулга болон, Залуучуудын хөгжлийн төв, Хүүхэд залуучуудын ордны мэдээллийг “Иргэний ерөнхий газрын Булган нисэх буудал”, хуваариа бизнес эрхлэгчид буюу Цэцэгчин зах болон түүний ойр орчмын дэлгүүр үйлчилгээний газруудын ажилтнуудад хийсэн.

“Залуучууддаа зориулав” болзолт сарын аяны удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулан байгууллага, сумдад хүргэлээ.

### ***Тав. Хөдөө аж ахуйн бодлогы хүрээнд:***

#### ***Мал аж ахуйн талаар :***

Энэ онд аймгийн хэмжээнд 1565.3 мянга хээлтэгч төллөхөөс 305.1 мянга хээлтэгч төллөсөн бөгөөд гүү 478, үнээ 3270, эм хонь 194490, эм ямаа 106874 буюу 27.7 хувь нь төллөсөн байна.

Гарсан төлийн 304.4 мянган буюу унага 474, тугал 3253, хурга 194141, ишиг 106626 бойжиж байна.

Том малын зүй бус хорогдол адуу 303, үхэр 434, хонь 1980, ямаа 1588, нийт 4304 толгой мал хорогдсон мэдээг аваад байна.

Сумдтай 7 хоногийн Лхагва гарагт төл бойжилт, малын зүй бус хорогдлын мэдээг авч нэгтгэн, Пүрэв гарагт ХХААХҮЯ, УМЭҮГ болон аймгийн удирдлагуудад мэдээлж байна.

“Мал аж ахуйн 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах аймгийн нэгдсэн төлөвлөгөө”-г боловсруулж төслөөр ЗДТГазарт хүргүүлэв.

Аймгийн нөөцийн газрын өвс, тэжээлийн чанар, хадгалалт, хамгаалалтын байдалтай танилцсан дүнг аймгийн Засаг даргын зөвлөл болон ИТХурлын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэв. “Булган-Шинэ хөдөө” дэд хөтөлбөрийн баримт бичгийн төслийг боловсруулж байна.

Мал аж ахуйн мэргэжилтний сургалт, семинарыг зохион байгуулсан. Уг сургалтанд “Малын удмын сангийн үндэсний төв”-ийн Булган дахь салбарын менежер, Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүд хамрагдав.

Засгийн газрын 2018 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 218 дугаар тогтоолын хүрээнд өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд аймаг 300 тн өвс, 95 тн тэжээл, сумд 1300 тн өвс, 436 тн тэжээл бэлтгэсэн. Сумдын аюулгүйн нөөцийн өвсний 30 гаруй, тэжээлийн 50 гаруй хувийг зарцуулсан мэдээг сумдаас аваад байна.

Монголын “Ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо”-ноос зохион байгуулж буй “Ноос боловсруулах үйлдвэрийн өртгийн сүлжээ” сэдэвт, Малын үржил, бүртгэлийн бодлогын зохицуулах газраас зохион байгуулж байгаа “Мал үржүүлэг, технологийн ажлын нээлт” сэдэв сургалтанд Мал үржлийн албаны дарга оролцсон.

### **Хүнс, газар тариалангийн талаар:**

Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн зөвлөгөөн, “Атар-60” жилийн ойн нээлтийн арга хэмжээг 2019 оны 03 сарын 11-ний өдөр зохион байгууллаа. Зөвлөгөөнийг Аймгийн Засаг дарга З.Батзориг нээж, тариаланчдад хандан илтгэл мэдээлэл танилцууллаа. Мөн ХХААГ-ын дарга Ч.Амгалан Газар тариалангийн үйлдвэрлэлийн 2018 оны үр дүн, 2019 оны зорилтын талаар илтгэл мэдээлэл хэлэлцүүлсэн. Зөвлөгөөнд Аймгийн ИТХ-ын дарга М.Оюунбат, Аймгийн Засаг даргын орлогч О.Гантулга, Ц.Бат-Өлзий зэрэг албаны хүмүүс урилгаар оролцлоо.

“Монголын тариаланчдын үндэсний холбоо”-ны Гүйцэтгэх захирал Ө.Болдсайхан, “Каритас Монгол” ТББ-ын агрономич С.Тэгшбаяр “Уртасгасан хугацаатай хүлэмж барих аргачлал, загварууд”, “B&T Analysis” ХХК-ийн захирал Т.Баттөгс “Дрон технологийг ХАА-н салбарт ашиглах нь”, УХЭШХ-ийн Доктор Т.Дэжидмаа “Үр тариа, төмс хүнсний ногооны өвчин, хортон шавьж, хор хөнөөл, тэмцэх арга”, Доктор Д.Цэвээндорж “Тариалангийн талбайн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх дэвшилтэт арга”, Доктор О.Ариунаа “Үр тариа, төмс хүнсний ногооны талбайн хог ургамал, хор хөнөөл, тэмцэх арга”, Бизнесийн зөвлөх Магистр М.Эрдэнэчимэг “Бизнесээс үүсэх стрессийн менежмент” сэдвүүдээр тус тус газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч 208 хүнд сургалт хийсэн.

“Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аяныг танилцуулах, аянд хамрагдах аж ахуйн нэгжийг бүртгэх уулзалтыг Булган сумын ЗДТГ-т зохион байгуулж



ХХААГ-ын дарга, СХХ-ийн дарга нар мэдээлэл хийж танилцууллаа. Уг уулзалтанд МХГ-ын байцаагч нар, ХХААГ, ЭМГ-ын мэргэжилтнүүд болон Булган сумын ХАА-н тасгийн мэргэжилтнүүд оролцож уулзалтанд ирсэн иргэдийн асуултанд хариулж, цаашид хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг танилцууллаа.

Тус уулзалтанд 3-р 11 жилийн захирал, ЭӨЦС-ийн менежер, 1-р 12 жилийн сургуулийн эмч, МСҮТ-ийн багш, ХАА-н МСҮТ, Спортын дунд сургуулийн менежер болон хувийн хэвшлийн хүнс, хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, хувийн эмнэлгүүдийн захиралууд нийт 30 гаруй хүн хамрагдсан.

Аянд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллагуудыг бүртгэхэд 4-р цэцэрлэг, 3-р 12 жил, “Энх-Үрс” ХХК, “Цанлиг” ХХК, “Хос гурван хас” ХХК-ууд өөрсдийн хүсэлтээр оролцох саналаа өгч бусад аж ахуйн нэгжүүдийг ажлын хэсгийн зүгээс урьж хамрагдах хүсэлт тавьсны дагуу хоол үйлдвэрлэлд МСҮТ, Спортын дунд сургууль, 1-р 12 жил болон “Анар” ХХК, “Өрнөх учрал” ХХК, “Элбэг эд” ХХК, “Өрнөх учралт” ХХК-ууд, хүнс үйлдвэрлэгч нараас “Дэлгэрэх” ХХК, “Арвайн-Эхлэл” ХХК, “Хустай бэйкери” ХХК-ууд зэрэг нийт 15 байгууллага аянд нэгдэхээр эхний ээлжинд бүртгүүлээд байна.

Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан энэ жилийг “Аюулгүй, ухаалаг бараа бүтээгдэхүүн” уриан доор тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотойгоор орон нутгийн “Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг”-ийн салбар зөвлөлтэй хамтран ажиллахаар уулзаж ярилцан, ШӨХТГ-аас ирүүлсэн мэдээллийг цахимаар цацаж, Стандарт хэмжилзүйн хэлтэс, ХХААГ-аас хамтран хүнсний тэмдэг, тэмдэглэгээг унших, хувцар савны тэмдэг тэмдэглэгээний талаархи мэдээлэл бэлтгэн байгууллага, иргэдэд хүргэн, гарын авлага материал бэлтгэн тарааж өгсөн.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр, Давсны хэрэглээг бууруулах аяны хүрээнд Нэгдсэн эмнэлгийн гал тогоонд “Давсгүй, эрүүл, ухаалаг хоол хэрэглэж хэвшье” уриатайгаар 3 сарын 15-ны өдрийн хоолыг бэлтгэн хэвтэн эмчлүүлэгчдэд хүргэх чиглэл, заавар зөвлөгөө өгч ажилласны дагуу энэ өдрийн хоолыг давс багатайтайгаар бэлтгэн үйлчилж байна.

03 сарын 16-ны өдөр Бугат суманд болсон “Төлчин эмэгтэйчүүдийн чуулган”-ны 200 гаруй малчин эмэгтэйчүүдэд давсны аян, түүний хэрэглээ, хүнсний бүтээгдэхүүнийг худалдан авахад анхаарах, хуванцар савны тэмдэг тэмдэглэгээний талаархи мэдээлэл хийсэн.

**Зургаа: Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын чиглэлээр:**

2019 оны 03 дугаар сарын 14-нд “Нийтийн эзэмшлийн талбайд мод бут тарьсан иргэн, нөхөрлөл, аж ахуй нэгжийг урамшуулах тухай журам”-ыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцууллаа.

Хуурайшилт ихэсч ой, хээрийн түймэр гарч болзошгүй нөхцөл байдал үүссэнтэй холбогдуулан ой, хээрт аялах, ан агнах, мод бэлтгэх, ойн дагалт баялаг ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахыг 2019 оны 03-р сарын 10-ны өдрөөс эхлэн түр хугацаагаар хориглосон аймгийн Засаг даргын 2019 оны А/109 тоот захирамж, 03 дугаар сарын 10-наас 6 дугаар сарын 10, 10 дугаар сарын 10-наас 11 дүгээр сарын 10-ны хооронд Бугат, Орхон, Сэлэнгэ, Хангал, Хутаг-Өндөр, Тэшиг сумдад 12 морин эргүүл ажиллуулахаар аймгийн Засаг даргын 2019 оны А/91 тоот захирамжийг тус тус гарган сумдад хүргүүллээ.

Ой, хээрийн түймэр гарах эрсдэлтэй улирал эхэлж байгаатай холбогдуулан ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлыг эрчимжүүлэн түймрээс урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлын төлөвлөгөө гарган, цагийн байдлын мэдээлэл авах, өгөх байнгын жижүүрийг ажиллуулах, хяналт шалгалтыг тогтмол хийх зэрэг албан бичгүүдийг сумдад хүргүүлээд байна. Аймгийн хэмжээнд 12 сумдад 150 морин эргүүл ажиллаж байна.

Булган аймгийн “Ногоон хөгжлийн хэтийн зорилт”, аймгийн Засаг даргын “Хөгжлийн хөтөч” хөтөлбөр, “Хүүхэд залуучуудад экологийн боловсрол олгох дэд хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийг байгаль орчныг хамгаалах уламжлалт зан заншил, зөв дадал зуршил олгох, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх хог хаягдлыг дахин ашиглах, мөн орчны бохирдол доройтлыг бууруулах, ногоон орчинг бий болгох талаар экологийн боловсрол олгох зорилгоор сургууль, цэцэрлэгүүдийн дунд “Эко цэцэрлэг”, “Эко сургууль” шалгаруулах болзолт уралдааныг аймгийн Засаг даргын А/93 дугаар захирамжаар 02 дугаар сарын 01-ээс 09 дүгээр сарын 15-ны хооронд зарлан сумдад хүргүүлээд байна.

Булган сумын гэр хорооллын айл өрх, нийтийн эзэмшлийн талбайд хог ангилан ялгах хогийн сав нийлүүлэх тендерт шалгарсан “Хурмастын хүлэг”, “Булган барилга”, “Тана орд” ХХК-иудтай гэрээ байгуулсан. Мөн сум дундын ойн ангиудад арчилгааны огтлолт хийх зориулалттай моторт хөрөө нийлүүлэхээр шалгарсан “Номадик лежендс тур” ХХК-тай гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийг хүлээн авлаа.

“Mongolia ITM-2019” олон улсын үзэсгэлэнд Булган аймгаас амралт, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 8 аж ахуйн нэгж оролцож, орон нутгаа сурталчилж байна. Мөн энэ үеэр аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах судалгааны баг аж ахуйн нэгжүүдийн төлөөллийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Байгаль орчны тэмдэглэлт өдрүүд болох “Дэлхийн ой, усны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх талаар удирдах ажилтны шуурхай цуглаан дээр мэдээлэл хийж, ундны ус хадгалах, зөөвөрлөх савны хэрэглээ, хуванцар савыг зөв сонгох мэдлэг олгох гарын авлагыг иргэдэд тараах ажлыг зохион байгууллаа. Мөн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд “Амьдралын эх нь ус-Усны эх нь ой” сэдвийн хүрээнд “Дэвжээ” тэмцээнийг зохион байгуулан шалгарсан 3 багуудыг өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах нь” сэдэвт зөвлөгөөнд газрын дарга, мэргэжилтнүүд оролцож, “Булган аймгийн цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж, орчны бохирдол” сэдвээр мэдээлэл хийлээ.

### ***Долоо: Цаг үеийн бусад мэдээлэл:***

Монгол улсын төсөв болон хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн Булган аймгийн Дулааны станцын барилга угсралтын ажил дууссантай холбогдуулан Эрчим хүчний сайдын тушаалаар Эрчим хүчний яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Дулааны хэлтсийн дарга Т.Батдондоогоор ахлуулсан улсын комисс ажиллалаа. Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Эрчим хүчний хөгжлийн төв, “Эрдэнэт ДЦС” ТӨХК, Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ГХБХБГ, Онцгой байдлын газар, Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй улсын комисс Дулааны станц, Ус дулаан дамжуулах

төв, нэгдүгээр контурын шугамын үйл ажиллагаанд хяналт тавьж, үүрэг даалгаврын биелэлттэйгээр ашиглалтад хүлээн авлаа. 2009 онд шаваа тавьснаас хойш 10 жилийн дараа ашиглалтад орж байгаа тус станц нь 35 МВт-ын хүчин чадалтай бөгөөд одоогоор 42 инженер, техникийн ажилтнууд ажиллаж байна. Манай аймгийн дэд бүтцийн салбарт томоохон дэвшил болсон тус станц ашиглалтад орсонтой холбогдуулан Булган сумын хэрэглээний халуун ус, дулааны шугамуудыг шинэчлэх, засварлах шаардлагатай байгаа тул орон нутгийн зүгээс хөрөнгөөр асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байна.

Аймгийн Засаг дарга 16 сум, 1 тосгоны удирдлагуудтай анх удаа цахим хурал зохион байгуулав. Сумдын удирдлагуудтай хийсэн цахим хуралд аймгийн Засаг дарга З.Батзориг, Засаг даргын орлогч О.Гантулга, Засаг даргын Тамгын газрын дарга О.Наранжаргал, зарим хэлтсийн дарга нар болон холбогдох агентлагийн дарга нар оролцсон юм. Тус хурлаар аймаг, орон нутгийн хаваржилт, мал төллөлт, газар тариалангийн бэлтгэл ажил, хуурайшилт, ой, хээрийн түймэр, шар усны үер зэрэг гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үүрэг чиглэл өглөө. Мөн орон нутгийн удирдлагууд яаралтай шийдвэрлүүлэх зарим асуудлаа танилцуулж, мэдээлэл солилцов. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга О.Наранжаргал хөдөө, орон нутгийн удирдлагууд заавал аймгийн төвд ирж асуудлаа шийдүүлэх биш, цаг хугацаа, хөрөнгө зардал гаргахгүйгээр богино хугацаанд мэдээлэл солилцох, шийдвэр гаргахад дөхөм болж байгаа тус цахим хурлыг цаашид тогтмолжуулж, хэрэгтэй гэдгийг онцолсон юм